**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Нийслэлийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/210/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа<br>Утас: 99108763, Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 273

танай ____________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦОЛМОН ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн,мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Мал эмнэлгийн газар Жайка-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас 362.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар, дээд шатны төсөв захирагчаас 218.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авснаар байгууллагын материаллаг бааз бэхжиж, үйл ажиллагааны орчин нөхцөл сайжирсан байна.

### Аудитын гол асуудал

Мал эмнэлгийн ерөнхий газраас мялзан, хонины цэцэг, шүлхий өвчний вакцины зардалд 234.8 сая төгрөг, Нийслэлийн захирагчийн ажлын албанаас эзэнгүй нохой, муурыг түр байрлуулах, асрах газрын ашиглалтын зардалд 604.6 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас мал, амьтны халдварт өвчин, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 135.5 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25\Dugnelt - 1.docx

1226050105

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 93.2 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - - docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **197,601,192.97** | **675,140,792.92** |
| **33** | **АВЛАГА** | **-** | **436,647,952.58** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 60,929,552.47 |
| **335** | **Бусад авлага** | **-** | **375,718,400.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 375,718,400.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **197,601,192.97** | **238,492,840.34** |
| **351** | **Түүхий эд материал** | **111,865,209.14** | **147,482,764.51** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 33,881,377.97 | 44,786,755.77 |
| 35130 | Эм боох материал | 77,983,831.17 | 102,696,008.74 |
| **354** | **Хангамжийн материал** | **85,735,983.83** | **91,010,075.83** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,305,633.00 | 7,330,033.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 52,499,721.83 | 66,736,771.83 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 9,924,784.00 | 324,326.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,005,845.00 | 16,618,945.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,634,083,545.79** | **1,947,273,182.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,634,083,545.79** | **1,947,273,182.11** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,592,087,385.79** | **1,904,562,022.08** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,398,772,454.50 | 1,423,827,654.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (170,113,391.32) | (194,718,804.26) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 656,449,928.52 | 656,449,928.52 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (463,533,434.22) | (490,699,928.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,243,196,553.37 | 1,593,613,543.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,116,827,128.43) | (1,112,661,510.77) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 159,492,328.91 | 159,878,425.16 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (124,822,425.54) | (141,153,953.04) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 61,153,100.00 | 68,153,100.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (51,680,600.00) | (58,126,433.36) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **41,996,160.00** | **42,711,160.03** |
| 39301 | Програм хангамж | 37,000,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (37,000,000.00) | (164,999.97) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,996,160.00 | 41,996,160.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,831,684,738.76** | **2,622,413,975.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **720,224,924.30** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **720,224,924.30** |
| **413** | **Өглөг** | **-** | **720,224,924.30** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 35,828,148.60 |
| 4136 | Бусад өглөг | - | 702,310,850.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 696,730,850.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 5,580,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,831,684,738.76** | **1,902,189,050.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,831,684,738.76** | **1,902,189,050.73** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,013,413,851.82 | 1,013,413,851.82 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,013,413,851.82 | 1,013,413,851.82 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **519,682,919.60** | **590,187,231.57** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 442,846,940.40 | 519,682,919.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 76,835,979.20 | 70,504,311.97 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 298,587,967.34 | 298,587,967.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,831,684,738.76** | **2,622,413,975.03** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,360,948,776.00** | **4,217,408,871.53** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **3,426,161,300.00** | **3,207,749,246.53** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,426,161,300.00 | 3,207,749,246.53 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **934,787,476.00** | **1,009,659,625.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 237,122,940.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 690,281,638.00 | 234,797,350.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,382,898.00 | 774,862,275.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **798,990,619.93** | **1,344,412,222.05** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | **798,990,619.93** | **1,344,412,222.05** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **200,007,107.00** | **216,807,300.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 200,007,107.00 | 216,807,300.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 206,082,200.00 | 359,568,725.65 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 392,901,312.93 | 768,036,196.40 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,159,939,395.93** | **5,561,821,093.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,083,103,416.73** | **5,491,211,027.76** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,795,166,396.83** | **5,170,355,697.47** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,508,194,100.75 | 2,687,593,255.17 |
| 210101 | Үндсэн цалин | 1,581,435,075.13 | 1,571,036,513.46 |
| 210102 | Нэмэгдэл | 471,696,925.49 | 462,627,564.85 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 335,189,885.15 | 504,178,223.07 |
| 210104 | Урамшуулал | 119,872,214.98 | 149,750,953.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **308,913,894.18** | **330,161,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 212,745,322.26 | 222,990,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,023,958.62 | 26,828,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,535,100.00 | 13,467,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,879,679.00 | 13,374,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 45,729,834.30 | 53,500,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **100,694,101.85** | **96,031,455.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,787,791.57 | 36,048,086.15 |
| 210302 | Түлш, халаалт | 7,417,508.05 | 4,919,368.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,279,873.83 | 5,819,660.59 |
| 210304 | Байрны түрээс | 70,208,928.40 | 49,244,339.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **75,904,452.72** | **138,969,759.77** |
| 210401 | Бичиг хэрэг | 18,527,330.00 | 15,969,180.10 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,660,436.00 | 34,652,703.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,340,758.32 | 8,030,716.67 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,294,888.40 | 77,677,160.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 1,081,040.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **566,959,113.86** | **891,140,521.93** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 566,959,113.86 | 862,946,521.93 |
| 210502 | Хоол, хүнс | | 28,194,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,113,000.00** | **93,134,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,656,000.00 | 76,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,457,000.00 | 93,057,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **57,566,000.00** | **65,560,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 57,566,000.00 | 65,560,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **767,173,573.00** | **649,637,936.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 750,162,820.00 | 630,074,220.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,260,580.00 | 2,698,238.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 801,733.00 | 3,316,231.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 209,000.00 | 187,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,332,320.00 | 7,984,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,907,120.00 | 1,877,347.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **371,648,160.47** | **218,126,969.48** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,925,178.90 | 75,206,434.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 470,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 170,722,981.57 | 142,450,535.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **287,937,019.90** | **320,855,330.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **112,267,752.33** | **27,722,663.53** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,000,000.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 74,304,754.33 | 17,822,663.53 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,200,100.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,762,898.00 | 9,900,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 175,669,267.57 | 293,132,666.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,669,267.57 | |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 293,132,666.76 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **5,083,103,416.73** | **5,491,211,027.76** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **76,835,979.20** | **70,610,065.82** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | | **105,753.85** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 105,753.85 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | | 105,753.85 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **76,835,979.20** | **70,504,311.97** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,360,948,776.00** | **4,217,408,871.53** |
| 1310 | Улсын төсвөөс | 3,426,161,300.00 | 3,207,749,246.53 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,426,161,300.00 | 3,207,749,246.53 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 934,787,476.00 | 1,009,659,625.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 237,122,940.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 690,281,638.00 | 234,797,350.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,382,898.00 | 774,862,275.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **200,007,107.00** | **216,807,300.00** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 200,007,107.00 | 216,807,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 200,007,107.00 | 216,807,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 200,007,107.00 | 216,807,300.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,560,955,883.00** | **4,434,216,171.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,514,507,793.00** | **4,338,038,971.53** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,226,570,773.10 | 3,956,254,088.66 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,508,194,100.75 | 2,687,593,255.17 |
| 210101 | Үндсэн цалин | 1,581,435,075.13 | 1,571,036,513.46 |
| 210102 | Нэмэгдэл | 471,696,925.49 | 462,627,564.85 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 335,189,885.15 | 504,178,223.07 |
| 210104 | Урамшуулал | 119,872,214.98 | 149,750,953.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 308,913,894.18 | 330,161,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 212,745,322.26 | 222,990,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,023,958.62 | 26,828,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,535,100.00 | 13,467,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,879,679.00 | 13,374,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 45,729,834.30 | 53,500,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 100,694,101.85 | 95,529,655.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,787,791.57 | 35,446,286.15 |
| 210302 | Түлш, халаалт | 7,417,508.05 | 5,019,368.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,279,873.83 | 5,819,660.59 |
| 210304 | Байрны түрээс | 70,208,928.40 | 49,244,339.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 67,444,708.32 | 64,934,237.37 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,662,830.00 | 10,857,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,540,020.00 | 25,052,245.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,340,758.32 | 7,653,642.37 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,901,100.00 | 18,730,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 342,234,512.00 | 212,551,285.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 342,234,512.00 | 184,069,285.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 28,194,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 288,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 50,341,483.00 | 126,774,270.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,214,983.00 | 6,806,600.00 |
| 210602 | Тавилга | | 1,320,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,785,500.00 | 27,339,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 44,341,000.00 | 91,308,070.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 57,566,000.00 | 63,580,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 57,566,000.00 | 63,580,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 780,096,973.00 | 356,534,586.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 763,086,220.00 | 336,970,870.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,260,580.00 | 2,698,238.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 801,733.00 | 3,316,231.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 209,000.00 | 187,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,332,320.00 | 7,984,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,907,120.00 | 1,877,347.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,085,000.00 | 18,595,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,085,000.00 | 18,475,200.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 120,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 287,937,019.90 | 381,784,882.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 112,267,752.33 | 27,722,663.53 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,000,000.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 74,304,754.33 | 17,822,663.53 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,200,100.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,762,898.00 | 9,900,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 175,669,267.57 | 354,062,219.34 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,669,267.57 | 3,914,552.58 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 350,147,666.76 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **4,514,507,793.00** | **4,338,038,971.53** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **46,448,090.00** | **96,177,200.00** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **46,448,090.00** | **96,177,200.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 46,448,090.00 | 96,177,200.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 46,448,090.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 46,448,090.00 | 96,177,200.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **46,448,090.00** | **96,177,200.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(46,448,090.00)** | **(96,177,200.00)** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,013,413,851.82** | **298,587,967.34** | **443,011,606.82** | **1,755,013,425.98** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (164,666.42) | (164,666.42) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,013,413,851.82 | 298,587,967.34 | 442,846,940.40 | 1,754,848,759.56 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 76,835,979.20 | 76,835,979.20 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,013,413,851.82** | **298,587,967.34** | **519,682,919.60** | **1,831,684,738.76** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,013,413,851.82 | 298,587,967.34 | 519,682,919.60 | 1,831,684,738.76 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 70,504,311.97 | 70,504,311.97 |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,013,413,851.82** | **298,587,967.34** | **570,716,753.29** | **1,902,189,050.73** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *(төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,671,284,300.00** | **3,422,586,068.25** | **248,698,231.75** | **93.2** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,491,284,300.00 | 3,205,778,768.25 | 285,505,531.75 | **91.8** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,491,284,300.00 | 3,205,778,768.25 | 285,505,531.75 | 91.8 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **180,000,000.00** | **216,807,300.00** | **(36,807,300.00)** | **120.5** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 180,000,000.00 | 216,807,300.00 | (36,807,300.00) | 120.4 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,671,284,300.00** | **3,422,586,068.25** | **248,698,231.75** | **93.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,671,284,300.00** | **3,422,586,068.25** | **248,698,231.75** | **93.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,642,577,000.00** | **3,394,863,404.72** | **247,713,595.28** | **93.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,688,102,000.00** | **2,687,593,255.17** | **508,744.83** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 1,616,273,400.00 | 1,571,036,513.46 | 45,236,886.54 | 97.2 |
| 210102 | Нэмэгдэл | 502,907,100.00 | 462,627,564.85 | 40,279,535.15 | 92.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 422,811,200.00 | 504,178,223.07 | (81,367,023.07) | 119.2 |
| 210104 | Урамшуулал | 146,110,300.00 | 149,750,953.79 | (3,640,653.79) | 102.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **330,161,600.00** | **330,161,600.00** | **-** | **100.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 222,990,000.00 | 222,990,000.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 26,828,700.00 | 26,828,700.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,467,600.00 | 13,467,600.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,374,500.00 | 13,374,500.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 53,500,800.00 | 53,500,800.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **99,531,300.00** | **90,238,682.74** | **9,292,617.26** | **90.7** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,713,700.00 | 30,255,313.77 | (10,541,613.77) | 153.5 |
| 210302 | Түлш, халаалт | 11,852,200.00 | 4,919,368.68 | 6,932,831.32 | 41.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,205,400.00 | 5,819,660.59 | 11,385,739.41 | 33.8 |
| 210304 | Байрны түрээс | 50,760,000.00 | 49,244,339.70 | 1,515,660.30 | 97.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **39,079,200.00** | **36,446,867.81** | **2,632,332.19** | **93.3** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,300,000.00 | 8,297,950.00 | 2,050.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,500,000.00 | 10,500,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,200,000.00 | 7,655,917.81 | 544,082.19 | 93.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,724,000.00 | 2,640,000.00 | 2,084,000.00 | 55.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,355,200.00 | 7,353,000.00 | 2,200.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **47,809,300.00** | **40,241,500.00** | **7,567,800.00** | **84.2** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 47,521,300.00 | 39,953,500.00 | 7,567,800.00 | 84.1 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 288,000.00 | 288,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **96,573,800.00** | **92,850,700.00** | **3,723,100.00** | **96.1** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,300,000.00 | 22,361,600.00 | 938,400.00 | 96.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 20,760,000.00 | 20,740,000.00 | 20,000.00 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 52,513,800.00 | 49,749,100.00 | 2,764,700.00 | 94.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **67,950,000.00** | **62,500,000.00** | **5,450,000.00** | **92.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 67,950,000.00 | 62,500,000.00 | 5,450,000.00 | 92.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **272,222,700.00** | **54,566,699.00** | **217,656,001.00** | **20.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 238,973,400.00 | 34,122,983.00 | 204,850,417.00 | 14.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 3,500,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,370,000.00 | 2,698,238.00 | 1,671,762.00 | 61.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 6,754,100.00 | 3,316,231.00 | 3,437,869.00 | 49.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 701,000.00 | 187,000.00 | 514,000.00 | 26.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,564,200.00 | 8,864,900.00 | 1,699,300.00 | 83.9 |
| 210807 | Газрын төлбөр | 7,360,000.00 | 1,877,347.00 | 5,482,653.00 | 25.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,147,100.00** | **264,100.00** | **883,000.00** | **23.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 777,100.00 | 144,100.00 | 633,000.00 | 18.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 370,000.00 | 120,000.00 | 250,000.00 | 32.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,707,300.00** | **27,722,663.53** | **984,636.47** | **96.6** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **28,707,300.00** | **27,722,663.53** | **984,636.47** | **96.6** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,822,700.00 | 17,822,663.53 | 36.47 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,884,600.00 | 9,900,000.00 | 984,600.00 | 91.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **93** | **88** | **5** | **94.6** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 83 | 79 | 4 | 95.2 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 8 | 1 | 88.9 |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **1,009,659,625.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **1,009,659,625.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 234,797,350.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 774,862,275.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **1,009,659,625.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **1,009,659,625.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **659,511,958.24** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **5,892,772.38** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 5,792,772.38 |
| 210302 | Түлш, халаалт | - | 100,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **29,685,543.86** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 2,559,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 14,552,245.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 1,195,898.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 11,377,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **174,959,785.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 146,765,785.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 28,194,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **114,920,770.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 40,137,000.00 |
| 210602 | Тавилга | - | 11,820,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 6,599,600.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 56,364,170.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **1,080,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 1,080,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **314,497,887.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 314,497,887.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **18,475,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 18,475,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **350,147,666.76** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **350,147,666.76** |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 350,147,666.76 |

***<u>Илрүүлэлт</u>***:

**1.** Тайлант хугацаанд төсвийн шууд захирагч 10,086,235.3 мянган төгрөгийн 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 170 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний 2,554,485.2 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "*тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор*", 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*", 6.10-т "*Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ

**2.** Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй төсөвт өртгийг хуваaж 39,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална*", 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваaж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

**3.** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42 ширхэг 1,671,935.4 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" 7.1-д *"төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*" гэж заасантай

нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

***4.*** Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "*комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх*" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоог бодож, хөрөнгийн дансны үлдэгдэлтэй тулган шалгаж байх.

***5.*** Бараа материалын шаардах хуудсыг эрх бүхий дарга, ахлах нягтлан бодогчоор баталгаажуулаагүй, өөр албан тушаалтан баталгаажуулж зөвшөөрөл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20 дугаар зүйлийн 20.1.4-т “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын шаардах хуудсанд байгууллагын дарга, ахлах нягтлан бодогч нар баталгаажуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

***6.*** Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "*Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж*:* Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

**7.** Эзэнгүй муур нохой тэжээхэд зориулж сийлбэртэй гэр худалдан авч төсвийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т ”*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж*:* Төсвийг эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн тооллого хийхдээ хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | | | | |
| 2 | Эзэнгүй муур нохой тэжээхэд зориулж сийлбэртэй гэр худалдан авсан нь төсвийг мөнгийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулсан | 1 | 7,000.0 | - | - | - | - | 1 | 7,000.0 | | | | |
| 3 | 42 ширхэг 1,671,935.4 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| 4 | Бараа материалын шаардах хуудсыг эрх бүхий дарга, ахлах нягтлан бодогчоор баталгаажуулаагүй, өөр албан тушаалтан баталгаажуулж зөвшөөрөл олгосон байна. | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| 5 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| | **Дүн** | **5** | **7,000.0** | **-** | **-** | **-** | **-** | **5** | **7,000.0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний | 1 | 2,554,485.2 | - | - | - | - | 1.0 | 2,554,485.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2,554,485.2 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **2,554,485** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **2,554,485** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийсэн байна. | 1 | 39,000.0 | | | 1 | 39,000.0 | | |
| **Дүн** | 1 | 39,000.0 | - | - | 1 | 39,000.0 | - | - |
| **НИЙТ** | **2** | **2,593,485.20** | **-** | **-** | **1** | **39,000.0** | **1** | **2,554,485.20** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 78/20810579 Улаанбаатар хот

НТАГ-2026/210/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг хуваах замаар 39,000,000.00 /гучин есөн сая/ төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална*". 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*" гэж заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг хуваах замаар бараа материалын худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга Б.Цолмон, ерөнхий нягтлан бодогч Б.Багаасүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090179